



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

**Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын
хугацаа сунгах тухай**

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 3 /гурав/ хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгагдсан хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/- д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ


ГИШҮҮД

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн
113 тоот тогтоолын
хавсралт



Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа
сунгасан хуулийн этгээдийн жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Олгосон дугаар	Хугацаа	Дугаарлалтын зориулалт
1	Стандарт, хэмжил зүйн газар	1800-2525	2023.10.24 2025.10.24	Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ
2	Мон пасс СА ХХК	1800-2535	2024.06.19 2026.06.19	Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ
3	Азифарма ХХК	1800-1801	2024.05.05 2026.05.05	Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ

----- оОо -----